




**Хар мод 2018**

## СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### . ЕРӨНХИЙ МӨДЭЭЛЭЛ

Сумын түүхэн товчоо 1925 оны 11 –р сарын 18нд нээгдсэн Чандмань уулын аймгийн анхдугаар хурал Дөрвөдийн баруун зүүн гарын хоёр аймгийг нэгтгэн Чандмань уулын аймгийн 8 хошуу 41 сум 115 баг, 660 арвантайгаар байгуулагдаж улмаар 1925 оны 11-р сарын 21-ний өдрийн Чандмань уул аймгийн Төгсбуянт уулын хошууг: Баянхайрхан, Баянзүрх, Баянмөрөн, Эрдэнэхайрхан, Эрдэнэ-Уул гэсэн 5 сумтайгаар байгуулахад одоогийн Сагил сум нь Баянзүрх нэртэйгээр анх байгуулагджээ.

Баянзүрх сумын анхны даргаар Н. Цагаанхүүг сонгожээ. 1931 онд БНМАУ–ын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар 5 аймгийн суурин дээр 13 аймгийг байгуулж, Чандмань-Уул аймгийг Ховд, Дөрвөд гэсэн хоёр аймаг болгож, Дөрвөдийн аймгийг 16 сумтайгаар зохион байгуулж, хошууг татан буулгаж аймаг, сум, баг гэсэн засаг захиргааны зохион байгуулалтад



шилжүүлснээр Төгсбуянт хошуу нь одоогийн Сагил-“Баянзүрх”, Түргэн-“Баянхайрхан”, Бөхмөрөн-“Баянмөрөн”, Баян-Өлгий аймгийн Цагааннуур-“Ойгор” зэрэг хоёр аймгийн 5 сум болжээ. Харин БНМАУ–ын СнЗ-ийн 1932 оны 12 –сарын 30–ны өдрийн 21–р тогтоолоор Дөрвөдийн аймгийг Увс аймаг гэж нэрлэхээр тогтоосон байна. Энэ зохион байгуулалтаар Сагил сум нь 7 багтай, / Гурван тураг, Боршоо, Зузаан бураа, Өндөр мод, Харигийн зүүн бэл, Цагаан гол, Баянзүрх / Тус сум нь үүсэн байгуулагдсан дээр дурьдсан цаг хугацаанаас хойш эдүгээ 90 жилийн түүхэн он жилүүдийг үдэж байна.


Одоо Сагил сум нь 635 өрх, 2464 хүн амтай, 168,8 мянган толгой малтай, засаг захиргааны 5 багтайгаар оршин тогтнож байна. Суманд төсөвт 7 байгууллага, хувиараа эрхлэх аж ахуй, компани 11, хоршоо 3, банк 2, ШТС 2, цагдаагийн хэсэг, холбоо, мобиком, скайтел сүлжээ, түүний дахин дамжуулах станц зэрэг үйлчилгээний байгууллагаас гадна амралт аялал жуулчлалын 2 бааз ажиллаж байна. Сагил сумын төв Хармод нийслэлээс 1428 км, Увс аймгийн төвөөс 61 км-ын зайд оршдог, Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон бөгөөд ОХУ –ын Хандгайтын чиглэлийн хатуу хучилттай засмал замаас 6,6 км зайд оршдог ба дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн

сумболно.Тус сумнь хойт талаараа ОХУ-ын Тувагийн Өвөр, Мөнгөн тайгын хошуудтай 160 км газраар, зүүн, урд, баруун талаараа Давст Түргэн, Бөхмөрөн сумуудтай хиллэдэг газар зүйн ашигтай байршилд оршдог.

### Газрын гадарга

Сумын газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын хэмжээ /га-аар/

Нийт	Үүнээс					
	ХАА-н газар	Хот тосгон бусад суурины газар	Зам шугам сүлжээний	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Улсын тусгай хэрэгцээний газар
379482.7	257892.2	202.1	2063.7	11829	24323	83172




Бэлчээрийн хянан баталгаа хийсэн судалгаагаар нийт бэлчээрийн 256384.7 га талбайтай


Д\Д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Талбай, га	Эзлэх хувь
1	Хөдөө аж ахуйн газар	257892.2	97,9%
2	Бэлчээр	256384.7	97,2%
4	Хадлан	384.0	0,1%
5	Тариалан	683.6	0.2%
6	Атаржсан		0.2%
7	Төмс, хүнсний ногоо		0.0%
8	Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар		0.1%

### Хадлангийн талбай ашиглалт

■ Иргэд, ААН эзэмшиж байгаа ■ Нөөц газар



### Газар эзэмшилт



Хөдөө аж ахуйн газар. Сумын хэмжээгээр 256384.7 га бэлчээрт ашиглагдаж байгаа бөгөөд сумын дунджаар нэг хонин толгойд шилжүүлэн тооцвол 1.69 га бэлчээр ноогдоно. Одоогийн байдлаар хадлангийн 384 га, 3 ААН, байгууллагад, тариалангийн 1232,3 га газрыг 18 иргэн, 3 ААН, байгууллагад, 188 иргэн 23,36 га газрыг гэр хашааны зориулалтаар тус тус өмчилж байна.

**Уур амьсгал.** Эрс тэс уур амьсгалтай, хуурайдуу сэрүүн зун, хүйтэн өвөлтэй. 1-р сарын дундаж температур -33,2, хөрсөндөө -33,8-40,0 градус, 7-р сарын дундаж температур агаарт +21,9, хөрсөндөө +31,1 градус байдаг. Жилийн дундаж салхины хурд 2-5 м сек, салхитай өдөр 44, үүнээс шороон шуургатай 38, цасан шуургатай хоног дундажаар 6, хаварт салхины хурд 20 м сек хүрдэг. Жилийн дундаж хур тунадасны нийлбэр 129 мм, үүнээс 8-р сард 75,6 мм ордог. Хөрсний болон уур амьсгалын тааламжтай байдал нь газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд сайн нөлөөтэй боловч цаг агаар хүндэрсэн үед тэжээлийн нөөц бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.

**Ойн нөөц.** Сум нь 11829 га талбай нутаг дэвсгэрийн 3,1 хувийг эзэлнэ. Үүнээс 9856,8 га нь ойгоор бүрхэгдсэн талбай, 1972,2 га нь ойгоор бүрхэгдээгүй талбай байна. Сүүлийн 3 жилд 8400,0 м<sup>3</sup> мод огтолж, ойн төлбөрийн орлогоос 7,0 сая төгрөгийг орон нутгийн орлогод оруулсан байна. Ойн нөөцийг олон жилийн туршид алс хэтийн бодлогогүй ашигласнаас Далт, Хойт хуудсан, Их зүрхний хавцал, Харгайт, Бураат, Хүсэрлэгийн хавцал, 3 голын сав зэрэг газрууд ойн сүйтгэлд хүчтэй өртсөн байна. Ой бүхий газарт амьдардаг малчид, иргэдтэй гэрээ хэлцэл хийж ойг хамгаалах нөхөн сэргээхэд тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай..

**Усны нөөц.** Томоохон голууд болох Хариг, Сагил, Боршоо голын сав газарт ХАА-н үйлдвэрлэл явагддаг, нийт 10 гол горхи, 81 булаг шандтай ба сүүлийн үед ширгэх хатах үйл явц ажиглагдаж байна. Их бага 5 нууртай ба Үүрэг нуур нь өргөн нь 18 км, урт нь 19 км, гүн нь 42 м, нийт усан талбай нь 24080 га, байгалийн үзэсгэлэнтэй нууруудын нэг юм. Үүрэг нуур нь загасны нөөцөөр баян жилд 50 т хүртэл ашиглах боломжтой. 18 булаг шанд бүртгэгдсэнээс одоо 4 гол горхи, 6 булаг шанд дэлхийн цаг уурын дулаарал, ойтой зүй бус харьцаснаас ширгэсэн байна. Инженерийн хийцтэй 10 худаг.

**Газрын хэвлийн баялаг.** Сум нь нүүрс, гөлтгөнө, цэрд, үнэт металл эрдэнэсийн чулууны төрлөөс алт, мөнгө, оюу, мана, гартаам, хаш, болор, зэсийн орд, шохойн чулуу, цахиур, бал чулуу, хүхэр, шөрмөсөн чулуу зэрэг бусад баялгаар элбэг юм. Эдгээрээс орон

нутгийн чанартай эдийн засгийн ач холбогдолтой .Гөлтөгний орд байгаа ба одоогоор ашиглалтгүй байна .

**Ан амьтны нөөц.**Олон улсын улаан номонд устах аюулд өртсөн хэмээн бүртгэгдсэн нэн ховор амьтан болох цоохор ирвэс / *Unica unica* Sch/, монгол улсын улаан номонд бүргэгдсэн аргаль хонь / *Qvis ammon* /, Янгир ямаа / *Capra sibirica* /, халиун буга / *Cervus elaphus* /, зэрэг амьтад бий. Эдгээр амьтдын тархац нутгийг Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулан Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газрын Цагаан шувуут уулын дархан цаазат газар хамгаалалтанд аваад байгаа билээ.Цагаан шувуут, Цагаан гол,Баянзүрх зэрэг газруудад 1997 оноос Дэлхийн байгаль хамгаалах сангийн шугамаар “Ирвэс хамгаалах төсөл” хэрэгжиж байна. Захзээлийн шилжилтийн үед буга, тарваганы тоо цөөрсөн хэдийч төр,засгийн бодлого, орон нутгийн иргэд, олон нийтийн хамгаалалтын үр дүнд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Агнуурын хураамж, ангийн отгийн үйлчилгээнээс жил бүр орон нутгийн орлогод төлбөр орж төсвийн нэгээхэн хэсгийг бүрдүүлдэг .

**Байгалийн ургамал.**Сумын нутагт хар мод, гацуур,хуш, нарс, бургас, улиас,хус, харгананойтой,бут сөөг,дэрс өлөн,чихэр өвс, ерхөг, бэд,агь, таана,ганга, зэрлэг сонгино, мөөг,



хялгана,бударгана,зээргэнэ,шарилж,хамхуул,мөн сэржмядаг,жамьянмядаг,яргуй, цагаан уул,бамбай ,царван,таван салаа, алтан гагнуур зэрэг эмийн ургамал,чацаргана, хад, тошлой, үхрийн нүд, мойл,нохойн хошуу зэрэг жимс жимсгэнэтэй. Эмийн ургамлын ашиглалт бага байгаа ч ХАА-н эдэлбэр газрыг дураараа ашиглах, атаржуулах, авто замын сүлжээ, малын зохистой харьцаа алдагдаж ямааны эзлэх хувь ихэссэн, дэлхийн цаг уурын дулаарал зэргээс шалтгаалж зэрлэг ургамлын нөмрөг дахь зүйлийн бүрдэл хомсдох, ургамлын тархац хязгаарлагдах, устах аюул нүүрлээд байна. Дөрвөлсөн мүгээ /алтан гагнуур/, Эмийн бамбай, Ацан ажигана, Тагийн гол гэсэр, Цагаан дэгд, Азийн жамьянмядаг, Эгэл марал цэцэг, Алтайн сонгино, Алтайн хүнчир, Ягаан цээнэ, Уралын чихэр өвс, Яшилдуу чацаргана, Морин зээргэнэ, Хонин арц зэрэг ургамал нь эко системийн хувьд нэн ховор болон ховордсон зүйлүүд болно.

**ТХГН дахь байгалийн үзэсгэлэнт байдал, түүх соёлын дурсгалт газар.**Монгол улсын Их хурлын 1993 оны 83-р тогтоолоор Байгалийн

унаган төрх шим мандлын тэнцвэрт байдлыг хангах, экологийн амин чухал үйл явцыг дэмжих, биологийн төрөл зүйл болон түүх, соёлын дурсгалыг хадгалан хамгаалах, хойч үедээ өвлөн үлдээх зорилгоор байгалийн бүс бүслүүрийн иж бүрдлийг төлөөлсөн ховор ан амьтан, ургамал, түүх соёлын дурсгал бүхий зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авсаны үр дүнд сумын газар нутгийн 9,4% буюу 35970,0 га /Үүнд: Цагаан шувуут, Баянзүрх зэрэг /газар хамрагдаад байна.

Цагаан Шувуут уул Далайн түвшнээс дээш 3496 м өндөрт өргөгдсөн уул. Цагаан шувуут уул нь Увс нуур, Үүрэг нуурын усан хагалбарт зүүн хойноосоо баруун урагш сунаж тогтсон байршилтай, хэрчигдэл ихтэй, шовх хянга, хяр хад, асга бүхий эгц хажуутай, дэлхийн улаан номд орсон хөхтөн ирвэс, Монголын улаан номд орсон аргаль, янгир, суусар, явлаг сар, хойлог зэрэг амьтадтай.

Хойт сайгийн хүрхэрээ Цагаан шувуут уулын ДЦГ-ын Хойт сайгийн аманд аманд байдаг 13м өндрөөс буудаг байгалийн үзэсгэлэнт хүрхэрээ юм. Нутгийн иргэд хүрхэрээг усан цайлзуур ч гэж нэрлэдэг. Хүмүүсийн очиж үзэх дуртай газрын нэг болжээ. Эндээс холгүй янгирын сүрэгтэй тааралдаж болох ба алтайн сонгино зэрэг ургамал элбэг ургадаг.

Эртний түүх, соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлсэд хүн хөшөө 3, гэрэлт хөшөө 1, дэлхийд болон Монголд алдартай Мжоо, Бужаа, Турагийн хадны сүг зураг, буган хөшөө 18, олон арван хиргисүүр бүртгэгдэн тэмдэглэгдсэн байна.

**Байгалийн аялал жуулчлал.** Сум нь аймгийн төвөөс 61 км хар зам, өндөр хүчдэл, холбоо харилцаа хөгжсөн, өндөр уул, ус, ан амьтан байгалийн үзэсгэлэнт газруудаар баян тул уулын спорт аялал, жуулчлал хөгжүүлэх ихээхэн боломжтой. Сумын төвөөс 40 км, аймгийн төвөөс 60 км ийн зайд тус бүрдээ 5-8 гэр бүхий жуулчны 2 бааз тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр баазад ирснээр Үүрэг нуурын усанд орж элсэнд биеэ шарах, чийрэгжүүлэх, хүрхэрээ үзэх, хадны сүг зураг үзэх, байгалийн үзэсгэлэн сайхантай танилцах боломжтой болно.



**Амьдрах орчин, цөлжилт.** Суурин газрын оршин суугчдын тоо өсөж, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэхийн хирээр хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байна. Сумын төвийн зүлэгжүүлсэн талбай 1,5 га, тарьсан мод 1020 шургаж байгаа нь ус, хөрсний боломжтой төвийн хувьд ногоон байгууламж бага байна. Иргэд зун, намрын улиралд зарим нэг газарт жил тойрон мал ажахуй эрхлэн амьдрах болсон, ургамал бэлчээрийн даац хэтэрсэн, малын сүргийн бүтэц

алдагдаж ямаан сүргийн эзлэх хувь ихэсэн, хадлан тариалангийн талбай ус, салхи бусад нөлөөгөөр элэгдэл эвдрэлд орсон нь цөлжилтийн гол шалтгаан болж байна.

МАНАЙ БАХАРХАЛ.

АИХ-ын депутат	11
Төрийн сайд	4
Аймгийн ЗД	2
Сумын дарга, ЗД	16
Хөдөлмөрийн баатар	2
Төрийн шагналт	1
Гавьяат цолтон	5
Академич	2
Доктор	44
Тэргүүн хамба лам	1
Зохиолч яруу найрагч	5
Улсын аварга, сайн малчин	13
Мянгат малчин	17
Аймгийн алдарт уяач	5
Үндэсний бөхийн харцага	1
Улсын начин	3
Аймгийн цолтон	12
Салбарын тэргүүний ажилтан	48

**САГИЛ СУМЭДГЭЭР НЭР ТӨРТЭЙ, ОЮУНЛАГ ХҮМҮҮСИЙНХЭЭ БҮТЭЭСЭН ОЮУНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР БҮТЭЭЛИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ИРЭЭДҮЙ ҮЕ ЗАЛУУСЫНХАА ИТГЭЛ НАЙДВАР ХҮЧ НӨӨЦ БОЛОМЖООР ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИХ САЙХАН ДҮР ТӨРХ ХАРАГ ДАЖ БАЙНА.**


#### **Эдийн засгийн салбарын хөгжил**

**ЖДҮ – ийн хөгжил.** Тус суманд МАА, газар тариалан, худалдаа, тээвэр зэрэг үйлчилгээний чиглэлээр ХХК-2, хоршоо-3, хувиараа хүн тээвэр эрхлэгч-8 ажиллаж байна. Үүнээс гадна иргэдхөрөө рам-3, Гагнуур – 2, Үсчин – 1, гутлын оёдол, засвар-4, мужааны цех-1, эсгийний үйлдвэр, боов, талхны цех, гурилан бүтээгдэхүүний цехийг ажиллуулж байна. Эдгээр аж ахуйн нэгж ард иргэдийн

ихэнх нь зориулалтын ажлын байргүй үйлдвэрлэл үйлчилгээ тогтмол явагдахгүй улирлын чанартай ажилладаг.

**ЖДҮ-ийн хөгжлийн нөхцөл байдлын шинжилгээ**

<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн хөгжил харьцангуй сайн</li> <li>• ЖДҮ хөгжих эхлэл тавигдсан</li> <li>• Байгалийн үзэсгэлэнт газар, түүх дурсгалт соёлын газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх</li> <li>• Газар тариаланг хөгжүүлэх газар, усалгаа тоног төхөөрөмж бүрдсэн</li> <li>•</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүн амын тоо цөөн</li> <li>• Худалдан авах чадвар муу</li> <li>• Бизнес эрхлэгчдийн хөрөнгийн хуримтлал санхүүгийн эх үүсвэр дутмаг</li> <li>• Байрсав хүрэлцээгүй</li> <li>• Зочид буудал, ахуйн үйлчилгээний төв байхгүй</li> <li>• Аймгийн төвд ойрхон тул бэлэн мөнгөний урсгал сумандаа эргэлтэнд ордоггүй</li> <li>• Иргэд, төр засгаас, орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжлэг сул</li> </ul>
<b>Боломж</b>	<b>Бэрхшээл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• ЖДҮ-ийг хөгжүүлэх талаар төр болон төрөл бүрийн төслийн дэмжлэг авах боломжтой</li> <li>• Иргэдийн санаачилгаар хөдөлмөрөөрөө хоршин ажиллах</li> <li>• ХАА-н гаралтай, ялангуяа малын гаралтай ноос, хөөвөр, хялгас, арьс шир, сүү, зэргийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх</li> <li>• Байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нөхөрлөл, бүлгүүд байгуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн жилүүдэд байгалийн давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн ган зуд, хэт хүйтрэлт, халалт</li> <li>• Банкны зээлийн хүү өндөр хугацаа богино</li> <li>• Байгалийн нөөц баялагт дулдуйтаж байгаа, нөөц баялагаа ашигладаггүй, хэт бэлэнчлэх сэтгэлгээтэй</li> </ul>



**Хөдөө аж ахуйн салбарын хөгжил.** Сагил суманд нутгийн байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицсон мал аж ахуй, усалгаатай газар тариаланг хөгжүүлж сумынхаа эдийн засгийн гол салбар болгон авч ирсэн түүхтэй.

**Мал аж ахуй.** Сагил сум 2017 оны байдлаар 166,8 мянган толгой малтай бөгөөд малчин өрх 435 байна. 2005 оноос хойш мал сүргийн тоо тогтвортой нэмэгдэж байсан боловч цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлаас 2009 онд малын тоо буурч малчин өрхийн тоо цөөрсөн ба 2012 оноос одоог хүртнд малын тоо 5 төрөлдөө өсөж малчин өрхийн тоо өссөөр байна

*Мал аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтийн хандлага*

Малын төрөл ба үзүүлэлт үд	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
<b>Малын тоо</b>									
Тэмээ	163	155	166	174	178	191	238	268	313
Адуу	2824	2515	2560	2700	3122	3694	4567	4890	5698
Үхэр	6136	4934	5572	5958	7144	8782	10345	9714	11177
Хонь	72483	49996	49138	53309	57190	66780	71909	73038	83156
Ямаа	65725	43856	47452	46555	50688	56458	58859	60489	66543
<b>Нийт дүн</b>	<b>147331</b>	<b>101456</b>	<b>104888</b>	<b>108696</b>	<b>118322</b>	<b>135905</b>	<b>145918</b>	<b>148399</b>	<b>166887</b>
<b>Малчин өрхийн үзүүлэлт</b>									
50 хүртэл малтай		119	95	78	92	73	72	78	62
51-100 малтай		64	47	54	68	49	61	104	59
101-200 малтай		124	138	112	102	154	162	162	162
500-599 малтай		135	120	135	149	64	68	61	76
1000- дээш малтай		46	55	59	55	19	21	29	31
<b>Нийт дүн</b>		<b>488</b>	<b>455</b>	<b>438</b>	<b>466</b>	<b>359</b>	<b>384</b>	<b>384</b>	<b>484</b>

**Газар тариалан.** Нийт 15,5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж 120,3 тонн ургацыг 2017 онд хураан авсан ба 2103 тонн байгалийн хадлан бэлтгэсэн дүнтэй байна.

	Хэмжээ	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
<b>Тариалсан талбай</b>										
Төмс	Га	4	7.2	6.7	5.6	5.4	7,4	7,8	5,2	15,5
Хүнсний ногоо	Га	2	3.5	4	3.5	7.2	5	5,3	6,3	7,1
Овьёос										7

Техникийн ургамал										100
Үр тариа	Га	242	310	365	150	150	150,0	150,0	150,0	40,0
<b>Гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл</b>										
Төмс	Тн	39.2	7.2	59.7	44.8	46.0	39,9	15,6	85,03	80,3
Хүнсний ногоо	Тн	18.9	3.5	42.9	41.0	72.8	35,7	18,25	46,215	40,58
Үр тариа	Тн	561.4	670.0	875.0	300.0	330.0	250	279	281	175,15
Овьёос										5,15
Техникийн ургамал										80
Хадлан	Тн	1100	1500	1500	2150	2050	2150	2374	2082	2103

Давуутал	Султал
<ul style="list-style-type: none"> <li>Газар нутгийн хувьд ойт хээр, хээрий, говийн бүсэд харьяалагддаг тул малчид малаа өсгөн амьдрах таатай орчин бүрдсэн</li> <li>Аймгийн төвд ойрхон, зам харилцаа сайн, мэдээлэл солилцох нөхцөл бүрдсэн</li> <li>Үржил шим сайтай хөрс, тариалангийн талбайтай</li> <li>Малын халдварт өвчний хувьд харьцангуй тайван бүсэд хамаарагддаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бэлчээрийн усан хангамж дутагдалтай тул зарим бэлчээрийн ашиглалт хангалтгүй</li> <li>Боломжоо ашиглан амьдрах талаар иргэдийн идэвхи санаачлага сул</li> <li>Мал, малчдын талаарх бодлого сул</li> <li>МАН-н бүтээгдэхүүний үнэ ханшмуу</li> <li>МАН-н мэргэжлийн боловсон хүчин дутмаг</li> </ul>
Боломж	Бэрхшээл
<ul style="list-style-type: none"> <li>Цаашид МАН, газар тариалан хослуулан бүтээмжтэй хөгжүүлэх, усалгааны тоног төхөөрөмжтэй</li> <li>ЖДҮ хөгжүүлэх боломжтой</li> <li>Бүлэг нөхөрлөл байгуулан ажиллаж буй боломжоо бүрэн дүүрэн ашиглах</li> <li>Эрчимжсэн аж ахуй, фермер хослуулан хөгжүүлэх боломжтой</li> <li>Малын тэжээл үйлдвэрлэх боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Усны нөөц багасаж бэлчээр, ургамлын гарц, бүтэцэд, сөргөөр нөлөөлсөн</li> <li>Байгалийн гамшигт үзэгдлын давтамж нэмэгдсэн</li> <li>Газар тариалангийн техник хэрэгсэл дутагдалтай, газрын үржил шим буурч байгаа</li> <li>Малын хулгай их гардаг</li> <li>Бэлчээрийн менежмент муу</li> </ul>

### Дэд бүтцийн салбарын хөгжил

Сагил сум нь эрчим хүчний нэгдсэн системд, хатуу хучилттай замаар Улаангом, хилийн боомттой холбогдсон, холбоо, мэдээллийн сүлжээ сайн хөгжсөн, аймгийн төвлөрсөн зах

зээл, Боршоогийн хилийн боомтод ойр байршсан зэрэг дэд бүтцийн давуутай сумын тоонд зүй ёсоор багтдаг.

*Сумын холбоо.*

1962 онд холбооны агаарын шугам ашиглалтанд орж, 1985 оноос АТ станцаар аймаг сум хот хооронд ярьдаг болов. 1984 онд орбитийн станцтай болж 1988 оноос монголын үндэсний телевизийн суваг үздэг болсон 1985, 2006 онуудад багийн холбоо ажиллуулан улмаар 2002 оноос телефон утасны тоон системд шилжсэнээр гадаадын ямарч оронтой шууд ярьдаг болжээ. 2004 онд тус суманд холбооны салбар шуудангийн алба нь стандартын шинэ байртай болж ард иргэд хөдөлмөрчиддөө хөнгөн шуурхай үйлчилж байна. Улмаар 2005 оноос мобикомын сүжээнд, 2006 онд Скайтелийн, Далтын дахин дамжуулах скайтелийн сүлжээнд 2010 онд мөн Юнителд тус бүр холбогдож 2009 оноос телевизийн 6 суваг үздэг болсон байна. Малчдын 85% нь олон сүвгийн антен ашиглан телевиз үзэж, 95% нь нарны гэрэлтэй болжээ.

Сумын ХААН банкны салбар нь суманд банк санхүүгийн үйлчилгээг хүргэдэг ба 2000 оноос үйл ажиллагаагаа тогтворжуулан шинэ байр ашиглалтанд оруулж онлайн системд холбогдсоноор бэлэн бус төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг түргэн шуурхай гүйцэтгэх нөхцөл бүрдүүлэн ажиллаж байна. Мөн 2012 оноос Төрийн банкны салбар байгуулагдан ажиллаж байна.

*2000 онд баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд хөдөөгийн сумдаас хамгийн түрүүнд холбогдож үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж нээгджээ. Мөн тус сумын нутгаар Улаангом Хандгайтыг холбосон хатуу хучилттай зам тавигдаж дэд бүтцийн хөгжилд эрс өөрчлөлт гарсан юм.*

*Дэд бүтцийн салбарын хөгжлийн нөхцөл байдлын шинжилгээ*

<b>Давуутал</b>	<b>Султал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Төв замд ойрхон</li> <li>• Холбооны шилэн кабелд холбогдсон</li> <li>• Хатуу хучилттай зам, эрчим хүчний системд холбогдсон</li> <li>• Банкны 2 салбартай</li> <li>• Төрөл бүрийн үйлдвэрлэл эрхлэхэд газар хүрэлцээтэй</li> <li>• Том зах зээлд ойрхон /Тува, Улаангом/</li> <li>• Байгалийн баялаг ихтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот төлөвлөлт байхгүй</li> <li>• Иргэдийн шилжилт хөдөлгөөнийх</li> <li>• Бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа сул</li> <li>• Үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зориулалтын ажлын байр байхгүй</li> <li>• Бизнесийн мэдээллийн сан бүрдээгүй</li> <li>• Бизнесийн холбоод донор байгууллагатай харилцаа холбоо байхгүй</li> </ul>
<b>Боломж</b>	<b>Бэрхшээл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Үйдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх боломжтой</li> <li>• МАА, усалгаатай газар тариалан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зах зээлийн багтаамж бага</li> <li>• Банкны зээлийн хүү өндөр, хугацаа богино</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Банк санхүүгийн үйлчилгээ өргөжсөн</li> <li>• Төслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</li> <li>• Монгол мал хөтөлбөр хэрэгжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн замын нөхцөл тааруу</li> <li>• Малчид эрчим хүч сүлжээнд холбогдоогүй</li> </ul>
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

### Төр, нийгмийн үйлчилгээний салбарын хөгжил

**Хүн амзүй, хөдөлмөр эрхлэлт.** Сагил сум нь 2017 оны жилийн эцсийн байдлаар 2464 хүн амтай ба нийт хүн амын 49,4% нь эмэгтэй, эрэгтэй 50,6% нь 0-18 насны хүүхэд, 42,1 % нь тэтгэврийн насны ахмадууд 230 буюу 9,3 %, хүн амын 47,0% нь ажиллаж байна. 2017 онд 66 хүүхэд шинээр төрж, 11 хүн нас барж, хүн амын цэвэр өсөлт 56 байна.

#### Сагил сумын хүн амын динамик судалгаа

Он		2011	2012	2013	2014	2015	2016	2017
Суурин тоо	хүн амын	2294	2231	2275	2201	2343	2382	2464
Үүнээс	Эрэгтэй	1182	1136	1172	1121	1190	1214	1248
	Эмэгтэй	1112	1095	1112	1080	1153	1168	1215
Бүх өрх		607	600	627	606	604	610	635

#### Сагил сумын хүн ам /хүйсээр/

Багууд	Хүйс	2014 он	2015 он	2016 он	2017 он
Сагил	Нийт дүн	2,201	2,343	2,382	2464
	Эрэгтэй	1,121	1,190	1,214	1248
	Эмэгтэй	1,080	1,153	1,168	1215
1-р баг, Баянзүрх	Нийт дүн	428	347	352	350
	Эрэгтэй	214	173	176	176
	Эмэгтэй	214	174	176	174
2-р баг, Боршоо	Нийт дүн	270	253	265	278
	Эрэгтэй	146	137	143	151
	Эмэгтэй	124	116	122	127
3-р баг, Өндөр мод	Нийт дүн	571	637	638	655
	Эрэгтэй	288	320	326	332
	Эмэгтэй	283	317	312	323
4-р баг, Үүрэг нуур	Нийт дүн	408	376	391	412
	Эрэгтэй	218	208	214	222
	Эмэгтэй	190	168	177	190
5-р баг, Хар мод	Нийт дүн	524	730	736	769
	Эрэгтэй	255	352	355	368

	<b>Эмэгтэй</b>	<b>269</b>	<b>378</b>	<b>381</b>	<b>401</b>
--	----------------	------------	------------	------------	------------

*Хүн ам боловсролын түвшин /2017 оны байдлаар*

Багийн нэр	Хүн амын тоо	Боловсролын түвшин					
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд
Баянзүрх	317	75	54	114	63	5	6
Боршоо	232	41	48	63	67	6	7
Өндөр мод	556	145	90	196	110	6	9
<b>Үүрэг нуур</b>	<b>337</b>	<b>81</b>	<b>85</b>	<b>80</b>	<b>77</b>	<b>3</b>	<b>14</b>
<b>Хар мод</b>	<b>666</b>	<b>27</b>	<b>158</b>	<b>181</b>	<b>146</b>	<b>38</b>	<b>116</b>
<b>Нийт</b>	<b>2108</b>	<b>369</b>	<b>435</b>	<b>634</b>	<b>460</b>	<b>58</b>	<b>152</b>

Тус суманд 2017 оны жил эцсийн мэдээллээр сумын хөдөлмөрийн насны хүн амын 59,8 хувь нь буюу 954 хүн ажил эрхэлж байна. Нийт хүн амын 64,7 хувь нь хөдөлмөрийн насны хүн бөгөөд үүнээс ажиллагчид 954, ажил эрхлээгүй 208 буюу 1,4 хувь, хөдөлмөрийн чадваргүй 139 буюу 8,7 хувь байна.

Нийт ажиллагчидыг авч үзвэл хамгийн олон нь буюу 428 хүн мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа ба. төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн буюу улсын төсөвт газруудад 109 хүн ажиллаж байна.

Ажилгүйдлийн түвшин 1.4 хувь байна.

*Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал*

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	
Нийт хүн ам	2300	2294	2231	2275	2201	2343	2382	2464	
Хөдөлмөрийн насны	989	909	895	971	1008	1416	1458	1596	
Нийт ажиллагсад	<b>614</b>	<b>523</b>	<b>537</b>	<b>564</b>	<b>686</b>	<b>574</b>	<b>577</b>	<b>587</b>	
Салбараар	МАА	409	384	389	409	410	414	420	428
	Худалдаа	6	8	10	10	12	12	11	10
	Тээвэр холбоо	11	11	12	14	14	12	12	12
	Банк, санхүү	4	4	7	7	8	8	8	8
	Төрийн захиргаа	34	36	36	36	36	36	36	36
	Боловсрол	44	42	44	47	47	47	49	50
	Эрүүл мэнд	25	25	26	27	27	27	23	23
	ААНБ	13	13	13	14	18	18	18	20

Шинээр ажилд орсон хүн	52	40	8	5	2	1	2	1
Бүртгэлтэй ажилгүйчүүд	28	47	35	26	31	34	32	25
Ажил эрхлээгүй хүн	137	139	150	149	154	166	184	208
Хөдөлмөрийн чадваргүй хүн	158	160	165	167	157	165	145	139

**Төрийн удирдлага, үйлчилгээ.** Сумын удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь орон нутгийн төрийн удирдлагын тогтсон журмын дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний Тамгын газар, багийн Иргэдийн нийтийн хурал, Засаг дарга гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Сумын удирдлагын бүтэц нь Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Баг гэсэн шатлалаас бүрдэх ба хурал 8, тамгын газар 18, баг 10 ажиллагсадтай бөгөөд нутгийн захиргааны зардлыг орон нутгийн төсвөөс, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллага улсын нэгдсэн төсвөөс, Улсын бүртгэгч нийгмийн халамж, даатгалын ажилтан, татвар, цагдаа, ус цаг уурын станцын ажилтнууд, төслийн ажилтан, байгаль хамгаалагч зэрэг нийт 9 хүн байгууллагын босоо тогтолцоогоор аймгийнхаа салбараас санхүүждэг.

***Төсвийн бүтэц.***

Тус суманд Засаг захиргааны 3 байгууллага, төсвийн 4 байгууллагад нийт 109 төрийн албан хаагч ажиллаж төрийн үйлчилгээг ард түмэндээ цаг хугацаанд нь чанартай хүргэн үйлчилж байна.

**1, Сумын нийт төсвийн бүтэц 2017 оны байдлаар**

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он
Төвлөрсөн төсөв	1100014.70	1106845.30	1082008.90
Орон нутгийн төсөв	725664,4	551212.20	501368.80

**2, Орон нутгийн төсвийн бие даасан байдал**

Орон нутгийн нийт төсөв	725664,4	551212,2	501368,8
Орон нутгийн орлогын эзлэх хувь	11,7	12,4	56,7
Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт / дүнгээр /	85559.20	68434.70	284404.20

### 3, Нийгмийн халамж.

Халамжийн сангийн нийт зарлага 219186,2 сая төгрөг болсон ба нийт зарлагын 32,8 % - г тэтгэмжинд, 26,8% - г халамжийн тэтгэвэрт, 10,4 % - г хөнгөлөлтөнд, 16,7 % одонгийн тэтгэмжид 13,08 % -ийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжинд зарцуулсан байна.

Үзүүлэлт	2017 он
Нийт зардал	219186,2
Тэтгэмж	71926,7
Халамжийн тэтгэвэр	59025,0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт	14879,3
Халамж асрамжийн үйлчилгээний болон тусламж хөнгөлөлт	7985,2
Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	28690,0
Алдарт эхийн одонгийн тэтгэмж	36680,0

### 4.Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлогын 66,66%-г тэтгэвэрийн даатгалын сан, 19,06%-г ЭМД-ын сан, тэтгэмжийн даатгалын сан 7,62-г, ҮОМШӨ болон ажилгүйдлын даатгалын сангийн орлого 6,66% тус тус бүрдүүлж байна.

НДСангий орлого

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Сангийн нийт дүн / мян төг /	84928,6	90523,1	96117,7	101712,3	147413,5	139518,9	164312,7
Тэтгэвэрийн даатгалын сан	56613,4	60342,7	64072,1	67801,4	98265,8	93003,3	109530,8
ЭМД-ын сан	16187,4	17253,7	18320,0	19386,4	28097,0	26592,3	31318,0
Тэтгэмжийн даатгалын сан	6471,6	6897,9	7324,2	7750,5	11232,9	10631,3	12520,7
ҮОМШӨ	4042,6	4308,9	4575,2	4841,5	7016,9	6641,1	7821,3
Ажилгүйдлын даатгалын сан	1613,6	1719,9	1826,3	1932,5	2800,8	2650,9	3121,9

Сумын төрийн удирдлага, үйлчилгээний байгууллагуудын гол зорилго нь иргэдэд хүртээмж чанартай шуурхай, үйлчилгээг

хүргэж байх явдал мөн болно. Тус сумзасаг захиргааны 5 багтай бөгөөд үүний 4 нь хөдөөгийн баг болно. Багуудын хөгжлийн байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв. Хүснэгтээс үзэхэд нийт өрхийн 7,8% нь малгүй байна.

*Багийн хөгжлийн зарим үзүүлэлтүүд /2017 он/*

	Нийт өрх	Хүн ам	Малчин	Малын тоо	Малгүй өрх	Сумын төвөөс алслагдсан байдал /км/
<b>Баянзүрх</b>	92	350	78	34571	7	15
<b>Боршоо</b>	72	278	72	19020	0	33
<b>Өндөр мод</b>	154	655	153	49335	0	70
<b>Үүрэг нуур</b>	103	412	83	46941	9	110
<b>Хар мод</b>	214	769	6	2268	100	0
	635	2464	392	152135	116	

**Боловсрол, соёлын үйлчилгээний салбар.**



*Боловсролын үйлчилгээ.* Сагил сумын сургууль нь 1940 онд байгуулагдсан, цэцэрлэг тус бүр нэг ажиллаж боловсролын үйлчилгээг хүн амд хүргэж байна. Хүн амын боловсролын байдлыг авч үзвэл дээд боловсролтой 152, тусгай дунд боловсролтой 74, техник мэргэжлийн анхан шатны боловсролтой 231, бүрэн дунд боловсролтой 277, бүрэн бус дунд боловсролтой 496, бага боловсролтой 290 байна. Бичиг үсэг бага мэдэгч 56, хүн,

сургуулийн болон өмнөх насны хүүхдүүд үлдэх хувийг эзэлж байна. Сургуулийн сургалтын чанар үр дүн дээшилж, материаллаг бааз бэхжлээ. Багш нарын заах аргын үр чадвар аль ч сургуулийнхаас дутахааргүй болж өрсөлдөх чадвар нь сайжирчээ.

Байр танхимын өргөн боломжтой, багш боловсон хүчний бэлтгэгдсэн нөөцтэй сургуулийнхаа ирээдүйн хөгжилд саад болж буй нэг хүчин зүйл нь аймгийн төвийн сургуулиудад хүүхдээ сургадаг хэвшил Үүрэг нуур, Боршоо багийн иргэдэд бий болсныг төр захиргааны байгууллага иргэд онцгой анхарч сургуулийнхаа хөгжилд хувь нэмрээ бүтээлчээр оруулах шаардлатай.

### **Сагил сумын хүүхдийн цэцэрлэгийн танилцуулга**



Увс аймгийн Сагил сумын хүүхдийн цэцэрлэг 1962 онд 3 орон тоотой 25 хүүхэдтэйгээр Хар модны дэнж дээр байгуулагджээ. Анхны барилга нь нэг давхар намхан 2 өрөө байсан. Анхны эрхлэгчээр Ш.Мижид багшаар О.Түмэнжаргал, Буянжаргал нар нь анхдагчид болон түүхийн хуудаснаа мөнхрөн үлджээ. 1963-1965 онуудад багш

Т.Нансал, 1965-1966 онд Д.Буянтогтох, 1966-1970 онд Ч.Цэвэлмаа нар ажиллаж байжээ. 1970-1977 он хүртэл багшаар Э.Янжмаа, асрагчаар Хасгаа 1977 онд багш С.Оюунчимэг багшаар тус тус ажиллаж байв. Цэцэрлэг нь хөгжлийнхөө үе шатуудад өргөжин хөгжиж 1978 онд 50 хүүхэдтэй 7 ажилчинтай ажиллаж байв. Үүнд эрхлэгчээр И.Юзэй багшаар Д.Удвал, С.Оюунчимэг, асрагчаар, Жавзмаа, тогоочоор Үржиг галчаар Б.Буянжаргал нар ажиллаж байжээ. Цэцэрлэгийн одоогийн энэ байр 1980 онд баригдаж ашиглалтанд орсон нь сургуулийн өмнөх насны хүүхдийн сурч хүмүүжих таатай орчин бүрдсэн юм.

1980 онд цэцэрлэгийн эрхлэгчээр Б.Цэрмаа багшаар Д.Удвал, С.Оюунчимэг, асрагчаар Б.Алтансүх, Д.Сэржим, А.Цэвэлмаа, тогоочоор Үржиг, сахиулаар Чулуун галчаар Ю.Дарь, туслах тогоочоор Урианхай нар ажиллаж байв. 1986 онд 3 бүлэг 75 хүүхэдтэй 12 ажиллагсадтай болж өргөжлөө. Энэ үед эрхлэгчээр Д.Удвал багшаар С.Оюунчимэг, Я.Бүрнээ, М.Энхтуяа, асрагчаар Б.Алтансүх, А.Цэвэлмаа, Д.Сэржим, тогоочоор Үрээхэй Уламбаяр, Угаагчаар Нансал, сахиулаар Х.Цэцэгээ, няраваар Аюурзана нар ажиллаж байв. 1987 онд няраваар Дэмбэрэл 1990 оноос Мийпэн нар тус тус ажиллаж байжээ. Өнгөрсөн он жилүүдэд цэцэрлэгийн хэмжээнд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүд гарч эрхлэгчийг няравтай хавсаргах, багш няравын ажил давхар гүйцэтгэх зэргээр ажиллаж байв.

1978-1990 оныг манай цэцэрлэгийн хөгжлийн нэг үе шат гэж хэлж болох юм. Энэ үед мэргэжлийн багш мэргэжлийн удирдлагаар бүрэн хангагдсан. Тэр үеийн хэллэгээр хүмүүжлийн 5 зарчим

болох оюун ухаан, ёс суртахуун, бие бялдар, гоо сайхан, эх оронч үзлээр хүмүүжүүлэх зарчмын дагуу сургалт хүмүүжлийн ажлаа явуулдаг байлаа. Энэ үед багш ажилчдын хүчээр хүнсний ногоо тарьж, туслах аж ахуй хөгжүүлэн зуны улиралд хөдөө багт гэр цэцэрлэг ажиллуулан малчдын хүүхдийг сурган хүмүүжүүлэхийн зэрэгцээ хонь, ямаа сааж цагаан идээ боловсруулан хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байв.

Манай цэцэрлэг улсын хэмжээнд анх удаа мал төллөлтийн үеэр малчдын хүүхдийг 24 цагаар 45 хоногийн хугацаанд авч ажиллаж байсан нь туршлага болж 1981 онд улсын хэмжээнд үзүүлэх сургууль хийж уг арга хэмжээнд МАХН-ын төв хорооны нарийн бичгийн дарга Д.Молломжамц, сайд нарын зөвлөлийн орлогч дарга Д.Цэвэгмид болон аймгийн удирдлагууд уулзаж тэр үед багшаар ажиллаж байсан Д.Удвал анх удаа Монголын Радиод ярилцлага өгч байв. Энэ үед цэцэрлэгийн ажилчдыг сум орон нутгийн ажилд дайчилдаг байв. Тухайлбал хадлан хадах, гар тэжээл бэлтгэх, тариа ногоо хураах, ямаа самнах, төллөлтийн үеэр айлд очиж мал төллүүлэх бүхий л ажилд оролцдог байв.

Манай хамт олон өөрсдийн хүчээр өвлийн түлшээ бэлтгэдэг байсан. Одоо ч энэ ажлаа хийсээр байна.

1990-2000 онд ардчилал зах зээлийн нийгэмд шилжих шилжилтийн үед цэцэрлэг хэвийн ажиллах нөхцөл боломж алдагдаж эхэлсэн. Манай аймгийн олон цэцэрлэг үүд хаалгаа барьсан тун хүнд жилүүд байлаа. Энэ үед цэцэрлэгийн эрхлэгээр Д.Удвал ажиллаж байсан юм. Төсөв хүрэлцээгүй төр засгаас хүүхдийн хоолны зардал өгч чаддаггүй, цалин мөнгийг 4, 5-н сараар ч тавихгүй цалингийн оронд архи хүртэл өгч байсан. Энэ жилүүдэд манай хамт олон туслах аж ахуй хөгжүүлэн өөрсдийн малаа хүнсэнд хэрэглэж ажилласаны үр дүнд цэцэрлэгийн үйл ажиллагааг нэг өдөр ч таслалдуулалгүй тэр үеийг давж гарсан юм. Ингэж ажилласнаар манай цэцэрлэг нь 2011 онд “Хүүхдэд ээлтэй” байгууллагаар 2012 онд сумын тэргүүний байгууллагаар тус тус шагнагдаж байжээ.

2015 онд 50 хүүхдийн өргөтгөл шинээр баригдаж одоогоор 100 хүүхдийг сурч хүмүүжүүлэх таатай орчин нөхцөл бүрдүүлэн ажиллаж байна. 2016 оноос эрхлэгчээр Б. Сольхүү, Багшаар Ц. Нарантуяа, Ж. Отгонжаргал, Д.Отгонжаргал, Б.Алтанзул, туслах багшаар Д.Цэцэгжаргал, Э. Баттуул, Д.Отгончимэг, .М. Алтантуяа, Няраваар Ш.Сайнбилэг, Тогоочоор Д.Сарантуяа, Ш. Туяа Үйлчлэгчээр Я. Мөнхцэцэг, Сахиулаар Б. Батмөнх, Машинистаар А.Нямдаваа, нягтлангаар Д. Мөнхтуул гэсэн 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2016-2017 оны хичээлийн жилд 4 бүлэг хичээллэж нийт 128 хүүхдийг хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна.



СӨНХ-ийн хамран сургалт жилээс жилд 1.5-2% ахиж, цага насны хүүхдийн хөгжлийн түвшингийн үнэлгээг боловсролгүй болгон ажиллаж байна. 2013 онд орон нутгийн хөгжлийн сангаас 18 сая төгрөгийн гүн өрмийн худаг, ном хөтөлбөрийн хүрээнд 2 сая таграгийн ном авч цэцэрлэгийн бүх бүлгүүдийг номоор хангалаа. 2014 онд боловсролын яамнаас 20 гаруй сая төгрөгөөр цэцэрлэгийн хатуу эдлэл, хүүхдийн ширээ сандал, цахилгаан хэрэгсэл нэг хоёрдугаар хоолны тогоо, цахилгаан жигнүүр махны машин хөргөгч хөлдөөгч будаа агшаагч, компьютер, хэвлэгч принтер гэх мэт гал тогооны иж бүрэн шинэ техник хэрэгсэл болон цахилгаан төгөлдөр хуур, ямаахай хөгжимөөр хангалаа.

Он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
<b>ЦЭЦЭРЛЭГ</b>									
Хамраг двал зохих хүүхэд	220	213	212	239	239	300	345	357	367
Хамрагдсан хүүхэд	135	121	120	120	120	223	222	223	225
Шинээр элссэн хүүхэд	28	28	24	30	28	55	49	38	55
<b>ДУНД СУРГУУЛЬ</b>									
Хамрагдсан хүүхэд	310	318	309	266	266	246	266	288	288
үүнээс: Малчдын хүүхэд	199	201	188	137	121	134	151	156	157
Шинээр элссэн хүүхэд	40	30	32	27	32	38	41	40	30
Сургууль завсардсан хүүхэд	0	0	0	0	0	0	0	0	0
Сурлагын стандарт хангалт /%/	Ст - 85,0 АВ - 32,1	Ст - 93,0 АВ - 39,2	Ст - 91,2 АВ - 34,0	Ст - 93,3 АВ - 38,4	Ст - 98,0 АВ - 34,0	Ст - 100,0 АВ - 74,0	Ст - 100,0 АВ - 70,0	Ст - 100,0 АВ - 76,0	Ст -100,0 АВ -77,0
Дотуур байрны хүүхэд	91	88	90	90	87	78	86	90	94

*Сургуулийн нөхцөл байдлын шинжилгээ*

<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн үйлчилгээ жигд хүртээмжтэй төлөвлөгдөн хэрэгжиж байгаа</li> <li>• Боловсон хүчний хангамж сайн</li> <li>• Техник тоног төхөөрөмж зохих түвшинд хангагдсан</li> <li>• Удирдлагын тогтвортой байдал</li> <li>• Үйл ажиллагаа явуулах зориулалтын байртай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүн амын тоо цөөн шилжилт хөдөлгөөн ихтэй</li> <li>• Хууль эрх зүйн мэдлэг дутмаг</li> <li>• Төсвийн хүрэлцээ хангалтгүй</li> <li>• Төрийн үйлчилгээний техникийн боломж муу</li> <li>• Иргэдийн нийгмийн идэвхи сул</li> <li>• Бэлэнчлэх сэтгэлгээ бий болсон</li> <li>• Хөгжлийн хэтийн болон урт хугацааны төлөвлөгөө байхгүй</li> <li>• Ажлын байр байхгүй, ажилгүйдэл их</li> </ul>

Боломж	Бэрхшээл
<ul style="list-style-type: none"> <li>• Төрөл бүрийн төсөл хөтөлбөр хэрэгжих</li> <li>• Байнгын цахилгааны эх үүсвэртэй</li> <li>• Гар утасны сүлжээнд холбогдсон</li> <li>• Хар замтай аймагт ойрхон байрлалтай</li> <li>• Мөдлэг боловсролоо тогтвортой дээшлүүлэх боломжтой</li> <li>• Мэдээллийн олон сувгаар мэдээлэл авах нөхцөл бүрдсэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал тодорхой бус</li> <li>• Зам харгүй муу тул хөдөөгийн иргэдэд жигд үйлчилгээ үзүүлэхэд хэцүү</li> <li>• Малын хулгай их байгаа нь малчдын амьжиргаанд нөлөөлдөг</li> <li>• Иргэд албан ёсны шилжүүлэггүйгээр хүүхдээ Улаангомын сургуулиудад суралцуулж байгаа нь сургуулийн хүүхдийн ирцэд сөргөөр нөлөөлж байгаа</li> </ul>

*Цэцэрлэгийн нөхцөл байдлын судалгаа*

<p align="center"><u>ЛООО ОЛ</u></p> <p>ОООООО” ООО ООО-О</p> <p>ОО ОООООО</p> <p>Л’ ОООООО О’ ООО-О</p> <p>ООО, О, ООУ ООО О’ ОО</p> <p>ОООООО-О</p> <p>ООО ООО-О</p> <p>Цахилгаан тоног төрөөрөмжөөр хангагдсан 100% мэргэжлийн багштай</p> <p>Компьютер хэрэгслээр хангагдсан</p> <p>Гүн өрмийн худагтай орчноо ногооруулах боломжтой</p>	<p align="center"><u>ООО ОЛ</u></p> <p>Хуучин байрыг ашиглах боломжгүй болсон</p> <p>Гадна дотно тоглоом хангалтгүй</p> <p>Интернетийн шугам сүлжээнд холбогдоогүй</p>
<p align="center"><u>ООООО</u></p> <p>с-О, ОООО ООООО</p> <p>О’ О’ “ О’ О</p>	<p align="center"><u>ОООО ОО</u></p> <p>О’ ОО-О ОО ОО О</p> <p>ООООО О’ ОО</p>



Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан Икил хуурын иж бүрэн зэмсэгтэй Иргэдийн урлагийн авьяас зохих түвшинд хөгжсөн Номын фонд арвинтай /хуучин/	Урлагийн хувцасны хангалт байхгүй Техник хэрэгсэл муудсан ашиглалтын хугацаа дууссан Музейн байргүй
Боломж	Бэрхшээл
Ардын урлагийн авьяастангуудтай Нутгийн алдартай дуучин, мэргэжилтэнгүүдтэй Орон нутгийн музейн үзэмрүүдтэй	Компьютергүй, интернетэд холбогдоогүй Сандал, тайз, гэрэлтүүлэг, хувцас, цонх, шил, машин хуучирсан ашиглалтын хугацаа дууссан

**Эрүүл мэндийн үйлчилгээ.** Сагил сумын хүн эмнэлэг нь 1937 онд байгуулагдсан. 1973 онд хүний их эмчийн салбарнь анх эг гэртэй, 3 ортой түр курсын эмчтэй байсан бол 1986 оноос одоог хүртэл 20 гаруй эмч ажилчинтай, түргэн тусламжийн машин, 2004 оноос эмнэлэгийн шинэ байр, орчин үеийн эмнэлэгийн багаж төхөөрөмжтэй мэргэжлийн эмч боловсон хүчинтэйгээр, 8 ор бүхий 145 км радиуст 2275 хүн амд эмнэлэгийн тусламжийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үзүүлж байна. Тус салбарт их эмч 2, эх баригч 1, угаагч үйлчлэгч 1, эмийн санч 1, сувилагч 4, багийн эмч 4, жолооч 1, тогооч 1 машинист 4 бүгд 27 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн 20 жилийн турш эхийн эндэгдэл гараагүй нь бидний ажлын багагүй амжилт юм.

Эмнэлгийн хамт олны ажлын гол чиглэл нь Монгол улсын засгийн газраас баталж гаргасан үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх сурталчилах хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, эрүүл аж төрөх зан үйлд сургаж төлөвшүүлэх явдал болж байна.

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Амбулаторын үзлэг	4641	5785	5209	6424	5334	6171	6721
Эмчлэгдсэн хүн	2239	2300	2267	2832	1796	2368	2480

Шинээр төрсөн хүүхэд	65	74	71	59	62	54	66
1000 амьд төрөлтөнд ногдох 0-1 насны хүүхдийн эндэгдэл	0	0	0	76.9	0	300	1
Нийт нас баралт	14	12	15	14	7	12	11
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	29	29	4	25	4	24	9

Хүн эмнэлэгийн нөхцөл байдлын судалгаа.

Давуу тал	Сул тал
<p><b>Дэд бүтэц сайн хөгжсөн</b> Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан</p> <p>Эмнэлэгийн шинэ байртай болсон</p> <p>Хөдөөгийн эхчүүдийг хүлээн авах, амаржуулах, амраах боломжтой</p>	<p><b>Багууд нь алслагдсан</b></p> <p>Боловсон хүчний санаачлага хариуцлага шаардлагын хэмжээнд хүрээгүй</p>
Боломж	Бэрхшээл
<p>Өөрсдийн хүчийг дайчлан бүтээн байгуулалт хийх</p> <p>Холбооны сүлжээг өргөн ашиглах боломжтой</p>	<p>Өрөө тасалгааны хүрэлцээ муу</p> <p>Ажиллах хүчний нөөц дутмаг</p>

### Байгаль орчны өнөөгийн нөхцөл байдал

Сагил сум нь өндөр уулын, бэсрэг уулын, толгодын, говь хээрийн гэсэн хэв шинжид хамаарагддаг. Байгалийн унаган төрхөө хадгалсан үзэсгэлэнт болон дурсгалт газруудтай. Мөн дэлхийн “улаан ном”-д орсон нэг зүйл хөхтөн-ирвэс, монголын “улаан ном”-д орсон 6 зүйл амьтан-аргаль хонь, янгир ямаа, баданга хүдэр, алтайн хойлог, халиун буга, суусар, зэрлэг гахай зэрэг амьтад, 175 зүйлийн жигүүртэн амьдардаг ан амьтны өлгий болсон нутаг юм. Сагил сум нь хуурай хээрийн бүсэд оршдог эх газрын эрс тэс, хуурайвтар уур амьсгалтай. Зуны улираалд агаарт 33-38 хэм, хөрсөнд 53-58 хэм хүрч халах ба өвөлд дунджаар 35-40 хэм хүйтэрч, 35-40 удаа цасан болон шороон шуурга шуурдаг. Сагил сумын ойн сан бүхий газар 11890 га талбайтай. Жилд дунджаар 1800м.куб модыг хэрэглээ болон түлшинд хэрэглэж байна.

Сагил сумын байгаль, орчны нөхцөл байдлын шинжилгээ

Давуутал	Султал
<ul style="list-style-type: none"> <li>• Ашигт малтмалын нөөц ихтэй</li> <li>• Эмийн ургамал элбэг</li> <li>• Байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх</li> <li>• Ховор ан амьтантай, Рашаан ус, булаг шанд элбэгтэй</li> <li>• Байгалийн үзэсгэлэнт газруудтай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ой модны нөөц багасч байгаа</li> <li>• Цөлжилт нэмэгдэж байгаа</li> <li>• Бэлчээрийн даац хэтэрсэн</li> </ul>
Боломж	Бэрхшээл
<ul style="list-style-type: none"> <li>• Аялал жуулчлал, уулын спорт хөгжүүлэх Цас их унадаг</li> <li>• Рашаан сувилал хөгжүүлэх</li> <li>• Спорт агнуур хөгжүүлэх</li> <li>• Цана, чарганы спортыг хөгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ой модны хуульбус ашиглалт</li> <li>• Ойн нөхөн сэргээлт хангалтгүй</li> <li>• Бэлчээрийн хортон шавьжихтэй</li> </ul>

Сагил сумын стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ.

Хөгжлийн тэргүүлэх чиглэл, нөөц боломжид тулгуурласан дараах бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжлийн стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн үйлчилгээ гэж нэрлэж байна.

**Байгалийн баялаг**

- 1, Чулуун нүүрс
- 2, Чацаргана, Үхрийн нүд
- 3, Уулын сонгино
- 4, Гөлтгөнө
- 5, Модон материал
- 6, Тоосго
- 7, Үр тариа
- 8, Илүү нугаламтай хонь

**Ахуйн үйлчилгээ.**

- 1, Цагаан ултай гутал
- 2, Гэрийн томсон оосор бүч
- 3, Гэрийн мод, модон эдлэл
- 4, Монгол гутал
- 5, Эмээл / баяд /
- 6, Сур аргамж, хазаар, ногт, чөдөр
- 7, Монгол дээл

**Цагаан идээ**

- 1, Ааруул, бяслаг
- 2, Шар тос
- 3, Нэрмэл архи
- 4, Сүү, тараг

**Аялал жуулчлал**

- 1, Цагаан шувуут, Хойт сайгийн хүрхэрээ, Могоо, Бужаагийн сүт зураг, Үүрэг нуур
- 2, Баянзүрхийн уул
- 3, Боршоон голын хавцал

**ОЮУНЛАГ ИРГЭДДЭЭ ТУЛГУУРЛАН БАЙГАЛИЙН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛ,ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ГАЗАР ТАРИАЛАН ХӨГЖСӨН, МАЛ АЖ  
АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛЭЭР АЙМАГТАА ТЭРГҮҮЛЭХ БҮСИЙН ТӨВ СУМ БОЛНО.**

